

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, Лхагва гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-6
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	7-31
<hr/>	
<i>1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/- ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	9-30
<i>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/</i>	30-31

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
04 дүгээр сарын 23-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 44 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Болормаа, О.Цогтгээрэл;  
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Оюун-Эрдэнэ, Л.Гантөмөр;  
Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Ж.Баярмаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хэлэлцэх асуудлын 2 дугаарт орсон Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасаж, хойшлуулах горимын санал гаргав.

Дээрх горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 58.8 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

***Нэг.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн газрын мэргэжилтэн Б.Энхцэцэг, “Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-ын захирал Г.Гүнжидмаа, “Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо” ТББ-ын тэргүүн С.Шаравдорж, “Глоб Интернэшнл төв” ТББ-ын хуульч Л.Галбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу хууль зүйн дүн шинжилгээ хийсэн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир, Д.Энхтүвшин, П.Сайнзориг, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, “Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-ын захирал Г.Гүнжидмаа, “Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо” ТББ-ын тэргүүн С.Шаравдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ч.Лодойсамбуу нар үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 12 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
10 цаг 44 минут.

### **ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ирцийг та бүхэндээ танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Батын Батбаатар, гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ингээд ирц бүрдсэн тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныг эхлүүлъя.

2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ТББХ-ны хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байгаа. 1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль шинэчилсэн найруулга хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, ЗГ 2025 оны 1 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хууль хэлэлцэх асуудал, хэлэлцэх эсэх. Байнгын хорооны тогтоолын төсөл Нэр дэвшигчийг бүртгэх тухай гэсэн ийм 3 асуудал байна. Хэлэлцэх асуудал.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүн. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Өнөөдрийн хэлэлцэх асуудалд байгаа Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхтэй холбоотойгоор Улсын Их Хурлын хууль зөрчигдөх ийм нөхцөл байдал үүсчих вий гэдэг дээр болгоомжлол байна. Тодруулбал Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд Дэд хороо гэсэн ийм зүйл байдаг. 27 дугаар зүйлийн 3-д Улсын Их Хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна. 27.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын, 27.4.Энэ хуулийн 27.3-д зааснаас бусад дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийн дагнан хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаараа шийдвэрлэнэ гэсэн ийм хуулийн заалт байдаг.

Өөрөөр хэлбэл Тусгай хяналтын дэд хороотой холбоотой татан буулгах юм уу, нийлүүлэх юм уу, салгах юм уу, байгуулах юм уу гэдэг ийм асуудлыг тухайн харьяалах Байнгын хороо буюу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын



хорооны саналыг үндэслэж, нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх ийм Их Хурлын хуулийн заалт байгаад байгаа юм. Тийм учраас энэ хуулийн шаардлагыг хангахгүй явчихвал энд хууль зөрчигдөх ийм асуудал үүсчих вий гэсэн ийм болгоомжлол байна. Тийм учраас энэ хуулийн шаардлагыг хангуулах хүрээнд энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хойшлуулах горимын санал гаргаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Эхлээд эхний горимын санал хураана. Баттөмөрийн Энхбаяр гишүүний гаргасан санал байна. Энэ дээр Улсын Их Хурлын тухай хуулийн 27.4.Энэ хуулийн 27.3-д зааснаас бусад дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийн дагнан хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ гэсэн ийм хуулийн үндэслэл байгаа юм байна. Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурал хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа харьяалах Байнгын хороод буюу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо 2-оос санал авч болно. Хууль чинь тийм утгатай байгаа. Улсын Их Хурлын бизнес болоогүй байхад Байнгын хорооноос санал авна гэж байхгүй шүү дээ. Энэ Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалттай асуудал учраас Улсын Их Хурал өөрөө хэлэлцэх эсэхээ шийдээд, энэ асуудлаар шийднэ гэнгүүт харьяалах Байнгын хороодынхоо саналыг аваад, тэгээд гээд 1 дүгээр хэлэлцүүлэг цаашаа үргэлжлэх ёстой байхгүй юу. Тэгснээс биш ингээд хаалгаар орж ирээгүй байхад ийм зүйл ярьж болохгүй.

2-т нь яг Энхбаярын хувьд уучлаарай сонирхлын зөрчилтэй харагдаж эхэлж байгаа байхгүй юу. Ийм өөрчлөлтийг хэлэлцүүлэхгүй байх сонирхол нь өөрөө Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Тусгай хяналтын дэд хорооны дарга учраас миний статусыг хөндөж байна гэдэг өнцгөөр хувьчилж хараад, хэт субъектив үнэлээд, тэгээд иймэрхүү байдал яривал энэ бол том сонирхлын зөрчил шүү. Ийм л үг хэлмээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ер нь Ямар ч байсан манай танхимд байгаа 2 хуульч маань хоёулаа л орж ирээд үндэслэлээ гаргалаа. Тэгэхээр энэ Байнгын хороогоор орж ирээд, тэгээд цаашаа уламжлагдаад чуулганаар хэлэлцэх асуудал тийм үү. Тэгээд сая Энхбаярын хувьд өөр үндэслэл гаргасангүй шүү дээ. Тэмүүжин гишүүний хэлсэнчлэн тэр өөр эрх ашгийн зөрчилтэй юм ярьсангүй. Миний хувьд зарчмын дагуу шийдэх нь зөв байх л гэж бодож байгаа юм. 27.4 дүгээр заалт. Би уншаад өгчихье. Энэ хуулийн 27.3-д зааснаас бусад дэд хороо байгуулах гэж байгаа шүү, 27.3-д нь нөгөө 5 дэд хороо байгаад байгаа шүү дээ. Энэнээс бусад дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийн дагнан хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн гэж байгаа шүү, үндэслэн. Тэгэхээр энэ Байнгын хороогоор ороод, энэ Байнгын хорооны дэд хороотой холбоотой асуудлуудыг нь тэр Байнгын хороон дээр нь ярилцаад, тэгж байж тэрний саналыг нь гаргаж ирээд, тэндээс гарсан саналыг үндэслээд дараагийн асуудлууд процессууд явах ёстой гэсэн ойлгож байгаа юм. Үгүй ээ үгүй. Таны тайлбар бол, би хууль ярьж байна шүү дээ. Би хууль ярьж байна шүү дээ. Үгүй ээ үгүй би бол хууль ярьж байна шүү дээ. Би хуулийн заалтыг ярьж байгаа байхгүй юу. Энийг үндэслээд гэж байгаа байхгүй юу, үндэслээд. Таны наадах чинь хууль санаачлах эрх бол би яриагүй шүү дээ. Хууль санаачлах эрхийг би яриагүй. Энэ дотор байж байгаа чуулганаар хэлэлцэх асуудлыг тухайн Байнгын хорооны үндэслэлийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ гэсэн байгаа шүү.

Хэрэлдээд яах вэ, горимын санал нэгэнт гарсан тул горимын саналаар санал хураах эрхтэй. Тэгэхээр Энхбаяр гишүүний гаргасан горимын санал буюу саяын энэ хуулийг түр хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Номинчимэг гишүүн санал гаргая.

**О.Номинчимэг:** Хуруугаа уншуулсан боловч нөгөө алдаа заагаад саналаа өгч чадсангүй. Санал хураалтыг хүчингүй болгож, дахин явуулж өгнө үү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Минийх бас орсонгүй. Тэгээд санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Хүчингүй болгох санал хураалт шүү. Тийм. Санал хураалтад 17 гишүүнээс 9 гишүүн оролцож, 52,9 хувиар санал дэмжигдсэн тул санал хураалт хүчингүй боллоо. Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Миний санал гарсангүй, протоколд миний саналыг дэмжсэнээр авна уу гэсэн хүсэлтийг гаргаж ирж байна. Санал хураалтад 17 гишүүнээс 10 гишүүн оролцож, 9 гишүүн оролцож 52,9 буюу дээрээс нь миний саналыг нэмээд ингээд санал дэмжигдсэнд тооцлоо. Санал дэмжигдлээ. Хэлэлцэх асуудалдаа оръё. Дараагийн асуудал. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт биш.

***Нэг.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. ЗГ-аас 2025 оны 1 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн хууль, хэлэлцэх эсэх. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгээ оруулъя. Ажлын хэсгийг оруулъя. Ариунхур Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга, Энхцэцэг Улсын Их Хурлын Тамгын газрын хууль, Ц.Батбаатар Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн шинжилгээ хэлтсийн дарга, С.Энхцэцэг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн дүн шинжилгээ хэлтсийн ахлах зөвлөх, Н.Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Н.Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Б.Энхцэцэг ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн, Г.Гүнжидмаа Хэвлэл мэдээллийн зөвлөлийн захирал, С.Шаравдорж Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн, Л.Ганбаатар Глоб интернэйшнл төвийн хуульч.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл танилцуулна. Алтангэрэл сайдын микрофоныг нээе.

**О.Алтангэрэл:** ТББХ-ны дарга болон эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ санаачлан боловсруулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж байна. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг 2021-ээс 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүний эрхийг дээдэлсэн нийгэм бүтээх зорилгын хүрээнд 5.5.9-д хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ гэж. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1 хүний эрх, эрх чөлөө бүлгийн 4.1.2.1.хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, бие даасан байдлыг хангах, тэдгээрийн редакцыг

эздийн нөлөөллөөс гаргах, сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэргэжлийн ёс зүйг баримтлан хариуцлагатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж тус тус заасан.

Техник технологийн дэвшил, цаг үеийн өөрчлөлт нь хүн бүрд үзэл бодлоо олон нийтэд хандан илэрхийлэх боломжийг улам бүр нэмэгдүүлж байгаа нь сайн талтай боловч нөгөө талаар үзэл бодлын илэрхийлэмжүүдээс бусдын нэр төр, нийгмийн ёс суртахуун, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах буюу тэнцвэрийг олох зохицуулалт бий болгох нь төрийн үүрэг. Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүл зүйг мэргэжлийн бөгөөд ёс зүйтэй нийтэлдэг байдлаар нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнөөс ялгах, хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг хангах, олон ургалч, чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан танилцуулж байна. Хуулийн төслийг боловсруулахдаа хэвлэн нийтлэх эрх чөлөөний үндсэн мөн чанар болох бусдын нэр төр, алдар хүнд, нийгмийн ёс зүй, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүйгээр хэвлэн нийтлэх боломжтой байх үзэл баримтлалын хүрээнд боловсрууллаа. Хуулийн төсөлд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн үйл ажиллагаа зэрэг нэр томъёог тодорхойлж өгснөөр иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнөөс сэтгүүл зүйн үйл ажиллагаа нь ялгаатай бөгөөд үүрэг хариуцлага өндөртэй болохыг тодорхойлох ач холбогдолтой.

Хуулийн төсөлд 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль дахь үзэл санаа, зохицуулалтыг бүрэн тусгахын зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбарт үүсээд байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор эзэмшлийн ил тод байдлыг хангах, эх сурвалж хамгаалах эрхийг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын эрх зүйн үндсийг бий болгохтой холбоотой зохицуулалтыг тусгалаа. Хуулийн төслийг боловсруулахдаа өмнө нь боловсруулагдаж байсан төслүүдийн алдаа оноог харгалзан үзэж, хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд хуулийн төслийн үзэл баримтлалыг ойлгуулах, санал зөвлөмжийг авах зорилгоор өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллалаа.

Хуулийн төслөөр ХМХ нь бүгд хуулийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах, 5 хувиас дээш хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, төрийн байгууллагаас авсан төлбөртэй нийтлэл, нэвтрүүлгийн талаар мэдээлэл ил тод байх, хэт төвлөрлөөс урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээллийн байгууллага нь мэргэжлийн редакцтайгаар үйл ажиллагаа явуулах, төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллагын нийтэлсэн мэдээ мэдээллийн талаар хүн, хуулийн этгээд тухайн редакцад болон өөрийн зохицуулалтын байгууллагад гомдол гаргах боломжтой байх, эх сурвалжийг нууцлах эрхийг баталгаажуулах зэрэг шинэлэг зохицуулалт тусган боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар хэвлэн нийтлэх эрх, түүнтэй холбоотой бусад ойлголтуудыг нэг мөр ойлгох боломж бүрдэх, хэвлэн нийтлэх эрхийг өргөн хүрээнд тайлбарласнаар зөвхөн редакцтай хэвлэл мэдээллийн байгууллага бус олон нийтийн эрх ашгийн төлөө хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлдэг бусад этгээдүүдийн эрхээ хэрэгжүүлэх боломж бүрдэх, хэвлэл мэдээллийн байгууллага, мэргэжлийн үйл ажиллагааны хувьд хараат бусаар ажиллах, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах эрхийг баталгаажуулснаар хууль бус байж болох үйлдлийг хэвлэл

мэдээллээр дамжуулан илчлэх, хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүй хөгжих боломж бүрдэнэ. Хэвлэл мэдээллийн хэт төвлөрөл бий болгохоос сэргийлснээр олон ургалч үзэл оршин тогтнох орон зай нэмэгдэж, эзэмшигч ил тод нээлттэй байснаар ХМХ-ийг улс төр, бизнесийн болон бусад хувийн зорилгоор ашиглахгүй болох юм. Иймд хуулийн төслийн үзэл баримтлалын хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хуулийн тайлбарыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 34.1.Тамгын газар энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан болон олон улсын гэрээ соёрхон батлахаас бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахын өмнө дараах асуудлаар хууль зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана гэж байна. 34.4.Хууль зүйн дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд хуулийн асуудал хариуцсан нэгжээс танилцуулж, тайлбар хийнэ гэж байгаа. Ингээд хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур танилцуулъя. 1 номерын микрофон.

**Ч.Ариунхур:** ТББХ-ны дарга, гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсээс гаргасан хууль зүйн дүгнэлтийг танилцуулъя. Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.5.5, 34.1 дэх хэсгийг үндэслэн хууль зүйн дүгнэлтийг гаргалаа. Хууль зүйн дүгнэлтийг 34.1.1-ээс 1.6-д заасан асуудлын хүрээнд гаргав.

Нэг.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцсэн эсэх талаар.

1.Төслийн 6.1 дэх хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, ХМХ-ийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль, захиргааны хэм хэмжээ, акт батлахыг, 6.2-т хэвлэн нийтлэх бүтээлд төрөөс агуулгын хяналт тогтоохыг, хэвлэл мэдээллийн байгууллагад төрөөс аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэхийг хориглохоор тусгажээ. Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг Иргэний болон олон улсын эрхийн тухай олон улсын фактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагаар зөвхөн хуулиар хязгаарлахаар заасан. Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим хуулиуд тухайлбал, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Онц байдлын тухай зэрэг хуулиудад ХМХ-ийн үйл ажиллагааг зохицуулах, хориглох, хязгаарлах зохицуулалттай байна. Иймд ХМХ-ийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлахыг хориглохоор төсөлд тусгасныг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээний хүрээнд дахин нягтлан хууль хоорондын уялдааг хангах нь зүйтэй байна.

Хоёр.Хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдсөн эсэх, төсөл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын хэрэгжих боломж, харилцан уялдааны талаар.

1.Төслийн 1.1-д хуулийн зорилтыг Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг хангах, олон ургалч, чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд оршино гэж өргөн хүрээтэй томъёолсон боловч төслийн 3, 4 дүгээр зүйлд энэ хуулиар сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр олон нийтийн эрх ашиг, сонирхлын төлөө мэдээллийг редакцтай хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан хараат бусаар, ил тодоор, хэвлэн нийтлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл хуулийн төсөл нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай гэсэн гарчигтай хуулийн зорилтыг өргөн хүрээнд тодорхойлсон боловч төсөлд ХМХ эзэмшдэг байгууллагатай холбоотой асуудлыг голлон тусгасан байх тул уг хуулиар зохицуулсан харилцааг нэг мөр болгох, Хууль тогтоомжийн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1-ийн агуулгыг товч илэрхийлсэн гарчигтай байх шаардлагад нийцүүлэх нь зүйтэй байна.

2.Төслийн 4.1.10-д илт худал мэдээлэл, ташаа мэдээлэл гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг хийж, ХМХ-ийн нийтэд түгээсэн мэдээлэл илт худал эсвэл ташаа гэж үзвэл эрх нь зөрчигдсөн этгээд гомдлоо редакц хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагад гаргаж болохоор, төслийн 8.5-д шүүхэд хандаж болохоор, төслийн 14.5-д тус тус тусгажээ. Илт худал, худал мэдээлэл гэсэн нэр томъёог 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 13.14, 14.8, 18.2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан хэрэглэсэн байх боловч илт худал мэдээлэл болон ташаа мэдээлэл гэж юуг ойлгох талаар нэр томъёоны тайлбар байхгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу нэг нэр томъёогоор өөр, өөр ойлголтыг илэрхийлэхгүй шаардлагыг хангах, хангах тул доор дурдсан нэр, томъёоны тайлбарыг Хууль тогтоомжийн хуулийн 30.2-т заасан Хууль зүйн хэлний зөвлөлөөр хянуулж, ойлголтыг нэг мөр өгөх шаардлагатай гэж үзэж байна. Үүнээс гадна илт худал мэдээлэл, ташаа мэдээлэл гэсэн нэр томъёог хуулийн төсөлд нэг удаа эшлэл авах байдлаар хэрэглэсэн байх тул нэр томъёоны тайлбар хэсгээс хасаж, 8 дугаар зүйлд заасан тайлбар хэлбэрээр оруулах боломжтойг анхаарах.

3.Төслийн 6.1-д ХМХ-ийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлахыг хориглоно гэсэн нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан Улсын Их Хурал төрийн гадаад, дотоод бодлогыг аль ч асуудлыг санаачилж болох хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхийг хөндсөн шинжтэй байж болзошгүй тул хэлэлцүүлгийн үе шатад анхаарах нь зүйтэй байна.

4.Төслийн 6.5-д төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааг тусгайлан сурталчлуулах бол хэвлэл мэдээллийн байгууллагыг хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулна гэжээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжид төрөөс ХМХ-д татаас өгөх, сурталчилгааг түгээх байгууллагыг сонгон шалгаруулах ажиллагаа нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үр дагавар үүсгэхгүй байхад анхаарал хандуулбал зохино гэснийг уг заалтыг хэлэлцүүлгийн шатанд, зөвлөмждөө зөвлөмжид анхаарах шаардлагатай байна.

6.Төслийн 6.8, 6.9-д Монгол Улсын тухай албан ёсны мэдээллийг олон улсад түгээх, сурталчлах зорилго бүхий хэвлэл мэдээллийн байгууллага улсын хэмжээнд нэг байж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд үйл ажиллагаагаа явуулахаар тусгасныг төслийн 6.10-д төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах

байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэргэдээ ХМХ ажиллуулахыг хориглоно гэсэн заалттай уялдуулах шаардлагатай. Уг байгууллага төслийн 9.1-д заасан хэвлэл мэдээллийн байгууллагын аль төрөлд хамаарах, эрх зүйн байдал нь ямар байх зэрэг нь тодорхойгүйгээс түүнд ажиллагсад, сэтгүүлч, удирдлагын эрх зүйн байдал мөн тодорхойгүй байх нөхцөл үүсэж болзошгүйг анхаарах.

7.Төслийн 13.2-т тухайн мэдээллийг нууцалсан эх сурвалжийг өөр арга замаар олж мэдэх боломжгүй бөгөөд хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой бодит хохирол учруулахуйц гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэслэлтэй гэж үзвэл эх сурвалжаа илчлэх эсэхээ сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага өөрөө шийдвэрлэнэ гэж тусгасан байна. Харин Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 34.2-т гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй гэж заасан нь олон нийтийн радио, телевизээс бусад хэвлэл мэдээллийн байгууллагад ялгаатай зохицуулалтыг бий болгож болзошгүйг анхаарах хэрэгтэй энэ хэлэлцүүлгийн шатад.

8.Төслийн 14.1 өөрийн зохицуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх байгууллага гэж хэвлэл мэдээллийн салбарын ёс зүйн хэм хэмжээг батлах, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн талаарх гомдлыг хянан хэлэлцэхээр тусгасан боловч одоо тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ын үйл ажиллагаатай хэрхэн уялдах, эвлэлдэн нэгдэх эрхийнхээ хүрээнд тухайн байгууллага нь ... хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг хэн, хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудал тодорхойгүй байгааг анхаарах.

Төслийн 3.1, 3.2, 4.1.1, 4.1.2, 4.1.5, 8.2, 8.1.4, 8.3, 4, 4.1.6, 10.1, 4.1.8, 5.1.1-д заасан нэр томьёо, үг хэллэг, найруулгыг Хууль тогтоомжийн хуульд нийцүүлэн жигдлэх, тодруулах, давхардлыг арилгах шаардлагатай байгааг мөн хэлэлцүүлгийн шатанд анхаарна уу.

Дүгнэлт төсөлд. 1.Төслийн зарим заалтын Монгол Улсын олон улсын гэрээ, Үндсэн хууль, хууль хоорондын уялдааг хангах нь зүйтэй гэж үзэв.

2.Хуулийн төслөөр хуулийн төслийн зорилтод заасан харилцааг бүрэн хамруулаагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой харилцааг голлон тусгасныг хэлэлцүүлгийн шатад анхаарч, төслийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх шатад Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нийцүүлэн нэр томьёо, найруулгыг нэг мөр ойлгогдохоор засах, хууль зүйн техникийн шаардлагыг хангуулах нь зүйтэй гэж үзлээ. Дүгнэлтийг танилцуулж дууслаа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Зулпхар гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Би 2 зүйл тодруулах гэж байна ажлын хэсгээс. Сая эх сурвалжийг нууцлах эрхийг баталгаажуулсан шинэ зохицуулалт оруулсан гэж байна шүү дээ энэ хуульд. Одоо байгаа нь яг ямар болчхоод болохгүй байгаа юм бэ? Тэгээд шинээр баталгаажуулснаар тийм зохицуулалт хийснээр ямар үр дүн, үр нөлөө хүлээж байгаа юм бэ гэдэг нэг ийм асуулт байна. Ялангуяа хэвлэлийн эрх чөлөөтэй уялдсан байдлаар. Нөгөө талдаа энэ чинь иргэний болон бусад субъектүүдийн эрх, эрх чөлөөний асуудал яригдана шүү дээ. Энийг хэрхэн зохицуулсан бэ гэдэг нэг ийм асуулт байна.

2 дугаарт би мэдээлэл сайн аваагүй учраас нэг зүйлийг тодруулмаар байна. Энэ орон нутагт телевиз, радионууд үйл ажиллагаа явуулдаг юм. Бүүр урьд нь ч гэсэн явуулж ирсэн, тэр нь уламжлаад явж байгаа. Энэтэй холбоотой ямар нэгэн зохицуулалт шинээр орсон юм бий юү гэж? Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Алтангэрэл гишүүн, сайд.

**О.Алтангэрэл:** Яг одоогийн үйлчилж байгаа хууль, эрх зүйн орчноор бол Үндэсний олон нийтийн радио, телевизийн сэтгүүлч эх сурвалжаа нууцлах эрхтэй. Бусад сайт, бусад төрлийн ХМХ-д ажиллаж байгаа сэтгүүлчид эх сурвалжийн хамгаалалт ерөөсөө байхгүй байгаа. Тэгэхээр бид энэ удаагийн хуулийн төсөл дээрээ эх сурвалж гэж сэтгүүлчийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээллийн үндэс болж байгаа үйл баримт, мэдээллийг өгч байгаа этгээдийг хэлье гээд эх сурвалжаа тодорхойлоод, тэгээд эх сурвалжаа нууцлах эрхийг нь бүрэн нээж өгч байгаа. Харин энэ хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой, бодитой хохирол учруулахуйц гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэслэлтэй гэж үзвэл эх сурвалжаа илчлэх эсэхээ сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага өөрсдөө шийдвэрлэ. Өөрсдөө шийдвэрлэ. Өнөөдөр түгээмэл болж байгаа үйл явдалд сэтгүүлчдийн зүгээс тавьж байгаа гомдол юу байна гэхлээр нэг асуудлын талаар мэдээлдэг, тэгээд гомдол гаргана, гомдол гаргаад очихоор наадхыг чинь хэн хэлсэн бэ, наад баримтыг чинь хэн чамд хэлсэн бэ гэж ингэж шаарддаг, хаанаас мэдсэнээ хэл гэж тулгадаг энэ байдал маш хэцүү байдаг. Ер нь зарчим нь мэдээллээ нууцлах нь өөрөө төрийн үүрэг. Мэдээллээ задруулахгүй байх тэр үүрэг нь цаад талдаа байгаа. Энийг олж аваад олон нийтэд ил болгоод гаргаж тавьсныхаа төлөө сэтгүүлч хариуцлага хүлээхгүй гэдэг ийм зарчимтай бид явж, энэ эх сурвалжаа нууцлах гэдэг энэ эрхийг нэлээн дэлгэрэнгүй бид дурдаж өгсөн юм.

2 дахь асуултын хувьд бид энэ хуулийн төслийнхөө хэлэлцүүлгийг нийт 6 удаа хийсэн. Үүнээс яг нэг хэсгийг нь орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулаад хийсэн. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаа хариуцсан сэтгүүлчдийн эвлэлийн төлөөлөгч Шаравдамба дарга маань тэнд сууж байна. Тэгэхээр орон нутгийн сэтгүүлчдэд тулгарч байгаа асуудал бэрхшээл юмыг нэлээн сонссон. Өнөөдөр яг бодитой тулгарч байгаа бэрхшээлүүд, цаашдаа юун дээр анхаарах вэ, энэ хуулийн төсөлд яаж ажиллах вэ гэдэг санааг бид хэлэлцүүлгийн үеэр нэлээн сонсож, тусгахад анхаарсан гэж хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. ТББХ-нд орж ирж асуулт асуух гэж байгаагийн гол учиг нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг дагалдуулж өргөн барьсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулахаар орж ирж байгаа юм. Энэ дагасан процессын хуулийн өөрчлөлтийг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэх боломжийг олгоосой гэсэн 1 дүгээрт ийм санал хүсэлт байгаа юм. Яагаад гэхээр энэ дагаж орж ирсэн өөрчлөлт дээр хэвлэл мэдээллийн байгууллагын редакцаар дамжсан сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээнд мэдээ, мэдээлэл бэлтгэх түгээх ажилд мэргэжлийн үүргээр оролцсон этгээдийг гэрчээр асууж болохгүй гэсэн хязгаарлалт орж ирж байгаа. Мөн Эрүүгийн хуулийн 19 болон 29 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор мэдүүлэг авч болно буюу Эрүүгийн хуулийн 19, 29 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс бусад гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг тогтоох зорилгоор сэтгүүлчээс мэдүүлэг авч болохгүй гэсэн хязгаарлалт орж ирж байгаа юм.

Тийм учраас энэ нөгөө хууль шүүхийн өмнө эрх тэгш байх нэг асуудал, нөгөө талаас эрүүгийн процессын хуулийн уялдаа холбоог хангах хүрээнд энийг мэргэжлийн Байнгын хороо нэлээн тодруулж ярих хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байгаа юм. Бусад улс оронд тодорхой субъект зааж гэрчээр асууж болохгүй тохиолдлыг маш нарийвчилж зохицуулсан байдаг. Тухайлбал өмгөөлөгчийг өөрийнх нь үйлчлүүлэгчийн өмгөөллийн нууцтай холбоотой асуудлаар нь гэрчээр асууж болохгүй. Сүмийн пастор лам зэргийг гэм нүглээ наманчилсан асуудлаар нь гэрчээр асууж болохгүй. Бага насны хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн сэтгэл зүйчийг тэр асуудлаар нь гэрчээр асууж болохгүй гэдэг ч юм уу. Өөрөөр хэлбэл субъектийг нь заахдаа ямар тохиолдол, үндэслэлээр асууж болохгүй вэ гэдгийг нь бичдэг юм. Тэгж байж ойлгомжтой болно. Тэрнээс сэтгүүлч хүн ерөөсөө ингэж нэг хулгайлах гэмт хэргийг юм уу, малын хулгайг харчихсан байхад тэр сэтгүүлч учраас тэр хүнийг асууж болохгүй гэдэг ийм бичилт байж болдоггүй. Энэ өөрөө нөгөө эрүүгийн процессын хууль тэр гэмт хэргийг илрүүлэх юманд садаа болдог. Тийм учраас энэ асуудлыг хэлэлцүүлгийн шатанд тодруулж, нарийвчлах бололцоо байгаа юу гэж сайдаас асууж байна?

**Ж.Бат-Эрдэнэ:** Алтангэрэл сайд хариулъя.

**О.Алтангэрэл:** Энхбаяр гишүүн нэлээн чухал асуудал хөндлөө. Түрүүнд нь энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль ер нь яригдаж байгаатай холбоотойгоор Энхбаяр гишүүнээс ийм төрлийн жишиг байдаг энэ асуудлыг судлаарай гэсэн ийм зөвлөмж өгч байсан. Бид ч гэсэн энэ чиглэлийн судалгаагаа нэлээн сайн хийсэн юм. Тэгэхээр ер нь эрүүгийн хэрэг Эрүүгийн процессын хуулийн өөрчлөлтийг бид нэлээн сайн хийж, хүний эрхийг хангах чиглэлээр олон өөрчлөлтүүд хийх шаардлагатай байгаагийн нэг нь яг энэ гэрчээр асуух журамтай холбоотой. Үнэхээр гаднын хуулиудад тийм юм байна. Хүн өөрийнхөө үйлдсэн гэм нүгэл гэж үзэж байгаа зүйлээ наманчилж хэлсэн зүйлийг нь лам хувраг хүнийг тэгээд цааш нь гэрчээр асуугаад байх нь зохимжгүй гэдэг ч юм уу, сэтгүүлчтэй холбоотой зүйлүүд дээр гээд. Бид энэ удаагийн хуулийн өөрчлөлт дээрээ яг бүрэн дүүрэн агуулгаар нь төдийлөн тусгаж оруулж ирж чадаагүй.

Тэгэхдээ олон улсын жишигт нийцүүлээд сэтгүүлч энэ эх сурвалжаа илчлэх талаар гэрчийн мэдүүлэг авахгүй байна. Өөрөөр хэлбэл гэрчийн мэдүүлэг аваад хэнээс, хаанаас авсан, хэн чамд ингэж хэлсэн, наад мэдээллийг хэн өгсөн, хэн захиалсан, ямар улс төрч гээд ингээд хөврөөд явдаг энэ асуудал дээрээ гэрчийн мэдүүлэг өгөхгүй. Сая дурдсанчлан мэдээж өөр төрлийн гэмт хэрэг, өөр нөхцөл



байдал дээр мэдээж өөрийнхөө хэвлэн нийтлэх эрх чөлөөнөөс гадуурх үйл ажиллагаа дээр мэдээж гэрчийн мэдүүлэг өгнө ингээд явна. Энэ асуудлыг яг энэ жишгээр нь бид тусгасан. Түрүүнд нь тунхгийн шинжтэй ярьдаг байсан зүйлийг процессжуулаад хууль дээрээ зааж өгөөд, дагаж байгаа энэ Эрүүгийн процессын хуулийнхаа өөрчлөлт дээр одоогоор ингээд бид оруулчхаад байж байгаа юм. Энэ Германы туршлага жишиг ч байгаа. Цаашдаа бид эрүүгийн процессын хууль буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийнхаа өөрчлөлтийн хүрээнд энэ асуудлыг яг үндсэн процессынхоо хууль тойроод нэлээн сайн ярьж, өөрчлөх шаардлага байгаа байх гэж бодож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн асуултаа асууна.

**Ц.Сандаг-Очир:** Энэ хууль зүйн дүгнэлтүүд орж ирээд байгаа юм. Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулиар бид ингээд хууль зүйн дүгнэлт гаргуулдаг болчихсон. Гол агуулга нь ерөөсөө Үндсэн хуулийн зөрчил гарах вий, хүний эрхийг хязгаарласан зүйл, заалт орчих вий гэдгээс л урьдчилан сэргийлж хууль зүйн дүгнэлт гаргуулаад байна шүү дээ. Тэгээд энэ дээр ерөөсөө анхаарал өгөхгүй байна, ач холбогдол өгөхгүй байна. Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороон дээр өнөөдөр ингээд сая хууль зүйн дүгнэлт танилцууллаа. 10 орчим зүйл, заалтууд анхаарах асуудлыг хэлж байна шүү дээ. Энийг хэзээд нь авч хэлэлцэх юм бэ? Энэ зүгээр нэг цаас үйлдвэрлээгүй шүү дээ. Ямар шатад нь энэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс гаргасан хууль зүйн дүгнэлтийг хөндөж үзэх юм бэ? Хууль санаачлагчид энэ дээр яаж анхаарал хандуулах юм бэ, хэзээд нь хандуулах юм бэ? Энэ зүгээр нэг ингээд нэг гаргасан байна лээ, энийг авч ч болно, авахгүй ч байж болно, анхаарч ч болно, анхаарахгүй ч байж болно гэсэн үг юм уу? Энийг нэг хэлье. Энэ чинь эргээд Үндсэн хуулийн цэц дээр асуудал оччих вий, Үндсэн хуулийн зөрчил үүсчих вий, хүний эрхийн зөрчил үүсчих вий гэдгээс л урьдчилан сэргийлж хэлээд байгаа асуудал шүү дээ. Тэгэхээр энэ шат дээр хэзээд нь, хаана анхаарал хандуулах юм бэ гэдгийг хэн хариулж өгөх юм бол доо?

Бас нэг зүйл бол энэ хууль дээр төрийн байгууллага, төрийн хууль, төрийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд дэргэдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлгүй байна гэдэг ийм асуудал орж ирж байх шиг байна. Ингэхээр Засгийн газар хэвлэл мэдээллийн албагүй байна гэсэн үг үү, Улсын Их Хурал өөрөө хэвлэл мэдээллийн албагүй байна гэсэн үг үү, яам, агентлагууд хэвлэл мэдээллийн албагүй байна гэсэн үг үү, орон нутгийн төрийн байгууллагууд хэвлэл мэдээллийн алба байхгүй, энэ асуудал хариуцсан ажилтан байхгүй ийм байдлаар цаашдаа явах гээд байна уу, үгүй юү? Энийг нэг тодруулж өгөөч. Хэрвээ ийм асуудал үүсвэл үүнээс үүсэх сөрөг үр дагаврууд юу болох юм бэ? Төрийн байгууллагууд өөрсдийнхөө үйл ажиллагааг ард иргэдэд мэдээлэх хуулиар олгогдсон үүрэгтэй байгаа. Энэ үүрэг нь яах юм бэ гэдэг ийм асуудал үүсэх гээд байна гэдгийг 2-т.

3-д тэр хууль зүйн дүгнэлт дээр бас л энэ илт худал мэдээлэл, ташаа мэдээлэл гэсэн ийм ойлголтуудыг ялгаа заагийг тодруулах хэрэгтэй байна гэсэн. Илт худал мэдээллээ тавивал яах юм бэ, ямар хариуцлагатай байх юм бэ? Ташаа мэдээлэл гэдэг нь хууль зүйн ямар агуулгыг илэрхийлж байгаа юм бэ? Хэрвээ ташаа мэдээлэл байсан байна гэвэл энэ нь ямар хариуцлагатай байх юм бэ, энийг яаж өөрчилсөн юм бэ гэдгийг энэ дээр нэг хариулт өгөөч?

Дараагийн нэг асуудал энэ дагалдсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулж байна. 31.1.1-д бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны, ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах гэсэн заалтыг нь хасаж байгаа юм байна. Тэгэхээр үндсэндээ хүндэтгэлгүй хандаж болох.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Алтангэрэл сайд хариулъя.

**О.Алтангэрэл:** Энэ дагах хуулиар хасагдаж байгаа зүйлийн талаар манай ажлын хэсэг хариулчхаарай. Би эхний 3 асуултад хариулчихъя. Энэ хууль зүйн дүгнэлтийг бид л хувьдаа хууль санаачлагчийн хувьдаа маш их ач холбогдол өгч байгаа юм. Ингээд хууль зүйн дүгнэлт дээр дурдагдсан зүйлүүд, Тамгын газрын хууль зүйн дүгнэлт дээр дурдагдсан зүйлүүд өөрсдийнхөө тайлбарыг бид ингээд яг зүйл болгоноор нь гаргачхаж байгаа юм. Энэ дундаас үнэхээр харж бодуштай ч зүйл байгаа, санал нийлэхгүй дутуу харчихсан байна гэж бодож байгаа зүйлүүд ч байгаа юм. Ингээд зөрөө гараад байдаг юм байна. Үнэхээр энэ хуулийн төслийг олон сар, заримдаа хэдэн жилээр дамнуулаад хийчихсэн, олон удаагийн хэлэлцүүлэг хийж, судалгаа хийсэн хүмүүсийн төсөл. Яг нэг төслийг барьж аваад ирүүлсэн материалыг үндэслээд гаргаж байгаа дүгнэлт хоёрын хооронд зөрөө гараад байдаг юм байна. Энэ дээр манай Сайнзориг гишүүн өчигдөр ХЗБХ-н дээр байр сууриа их тодорхой илэрхийлж байна лээ. Энэ үйл ажиллагаа буруу яваад байна шүү, буруу жишээ тогтоод байна шүү гээд. Энэ дээр санал нэгтэй байгаа. Тэгэхдээ бид Улсын Их Хурлынхаа энэ үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах үүргийнхээ дагуу бүх зүйл дээр нь өөрсдөө тайлбар хийгээд, ингээд ач холбогдол өгөөд явж байгаа гэдгээ хэлье.

Энэ төрийн байгууллагын Хэвлэл мэдээллийн алба гэдэг дээр ингэж байгаа юм. Хэвлэл мэдээллийн байгууллага гэж юуг хэлэх юм бэ гээд хуулийн төсөл дээр бид редакциягаар сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим хуудас зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшдэг хуулийн этгээдийг гэж байгаа юм. Тэгэхээр ЗГ-ын Хэвлэл мэдээллийн алба гэдэг юм уу, энэ хэвлэлийн төлөөлөгчид орохгүй. Тэгэхдээ бидэнд цаашдаа бусад өөр хуулиудаар зохицуулах, шаардлагатай бол энэ хуулийн төслийг хэлэлцэх явцдаа өөрчлөлт оруулах нэг зарчмын шинжтэй том зүйл байгаа юм. Лодойсамбуу гишүүн энэ асуудлыг нэлээн сайн дэвшүүлж тавьж байгаа. Энэ юу вэ гэвэл төрийн байгууллага төрийн мөнгөөр буюу татвар төлөгчдийн мөнгөөр ямарваа нэг контент үйлдвэрлэгч баг, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй дүйцэхүйц ийм зардал гаргаж үйл ажиллагаа явуулж байна. Төрийн өмчит компаниуд төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн зах зээлд үзүүлж байгаа нөлөөлөл энэ бусад хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй нөхцөл нөлөөллөөс үлэмж том байна. Өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн үлэмж хэмжээний мөнгө энэ зах зээл рүү яваад, эргээд энэ нь сөрөг үр дагавар үүсгэж байна. Ийм учраас энэ асуудлыг цэгцлэх ёстой гэдэг дээр Лодойсамбуу гишүүн байр сууриа илэрхийлээд байгаа. Манай хэлэлцүүлэгт орсон энэ асуудлыг хөндсөн бүх хэвлэл мэдээллийн байгууллага хэлж байгаа юм. Сайн сэтгүүлчдийг түүгээд авчихдаг, өөрсдөө мөнгөөр зоддог, студи байгуулдаг, компьютер ингээд контент хийдэг ийм юмтай болчихсон, энийгээ хязгаарлая гээд байгаа юм.

Хуулийн төсөл дээр ганцхан энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд ийм гадаадад мэдээлдэг, зөвхөн гадаадад үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд

байж болохоор заасан юм байна лээ. Энэ бол ерөөсөө цэвэр МОНЦАМЭ. Маш товчхондоо хэлбэл МОНЦАМЭ. Олон улсад байдаг жишгээр улс орныхоо дотоод бодлого шийдвэрийг олон улсад сурталчлан таниулдаг, зөвхөн гадагшаагаа чиглэдэг, ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг энэ жишиг байх юм бэ гээд, байх ёстой гээд бид ингэж оруулчихсан байгаа юм.

Тэр илт худал мэдээлэл, ташаа мэдээлэл дээр бид энэ хуулийнхаа төслийн дэвшилт гэж үзэж байгаа нэг хэсэг байгаа юм. Өнөөдөр илт худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэг байгаа Эрүүгийн хууль дээр. Ингээд илт худал мэдээлэл тараасан гэсэн этгээдийг байцаагч юм уу мөрдөгч дуудаад юу гэж асуудаг вэ гэхлээр энэ чинь худал юм уу, илт худал мэдээлэл гэдгийн хооронд ялгаа байхгүй учраас практик дээр гарсан шүү дээ, 15 удаа гадагшаа явсан гэж гүтгэсэн. Гэтэл тэр хүн бол 13-хан удаа явсан байсан гэдэг ийм тохиолдол гарсан шүү дээ. Тэгэхээр энэ бол илт худал мэдээлэл биш. Сэтгүүл зүйд бид эндүүрэл, ташаарал гэдэг энэ зүйлүүдийг бид хүлээн зөвшөөрч байх ёстой юм билээ. Харин илт худал мэдээлэл гэдэг бол бодит баримттай нийцээгүй, тухайн этгээдийг гүтгэх зорилгоор байдаг илтэд худал мэдээлэл гээд, одоо яг бид энэчээнээ тодорхойлоод оруулчихсан байгаа илт худал мэдээлэл. Энийг энэ хуулийн төсөлд оруулснаар ямар үр дагавар үүсэх вэ гэвэл өнөөдөр хүн болгоныг дуудаад зөрөөтэй, эндүүрсэн, ташаарсан, алдсан юм болгон дээр нь чи илт худал мэдээлэл тараалаа гэх боломжгүй болж байгаа юм. Өөрөөр хэлбэл илт худал мэдээлэл гэж ийм зүйлийг хэлнэ гээд хүн, хуулийн этгээд улс оронд санаатайгаар хохирол учруулах зорилгоор түгээсэн ор үндэслэлгүй худал мэдээлэл, баримт сэлтийг гээд.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг 3 номер уу, хэд юм бэ, 5 номер уу? Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

**Г.Гүнжидмаа:** Баярлалаа та бүхэнд, энэ өдрийн мэндийг хүргэе. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн буюу хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагын гүйцэтгэх захирал байгаа. Хэвлэл мэдээллийн зөвлөл 10 жилийн үйл ажиллагаа явуулсан, ТББ-ын чиг үүргээр ингээд ажилладаг. Саяын асуулттай холбоотойгоор үнэхээр яг бид энэ төрийн байгууллагууд мэргэжлийн сэтгүүл зүйн редакцуудтай өрсөлдөх хэмжээний зохион байгуулалтад орж, нөөц зарцуулж, өөрсдийн мэдээлэл сурталчилгааны ажлыг сэтгүүл зүйн үйл ажиллагаанаас давж хийж байна гэж үзэж байгаа учраас энэ асуудлыг хөндөж тавьж байгаа. Аливаа асуудал нь ардчиллын гол тулгуур баганууд буюу хэвлэл мэдээлэл, жишээлбэл шүүх, парламент бид үүрэг чигээ дор дороо ойлгож, харилцан бие биеэ дэмжиж, яг нөгөө чиг үүргээ нягт нямбай биелүүлэх тухай байгаа юм. Тэгэхээр мэдээлэл харилцаа төрийн байгууллагууд бол олон нийттэй харилцах албатай байж болно. Энэ чиг үүрэг нь зөвхөн хэвлэл мэдээлэлд мэдээлэл дамжуулах, түүнтэй.../үг тасрав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 5 номерын микрофоныг дахиад сунгая, 6 номер.

**С.Шаравдорж:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Сандаг-Очир гишүүний асуулт яг нэг ийм боломж.../үг тасрав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Өөрийгөө танилцуулаарай.

**С.Шаравдорж:** Би Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн Шаравдорж гэдэг хүн байна, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн удирдах зөвлөлийн дэд даргын сонгуультай. Сандаг-Очир гишүүний саяын асуусан асуултад нэг ийм үед энэ тухай хөндөж ярих юм сан гэж бодож явдаг юм. Энэ төр, төрийн өмчит аж ахуйн нэгж, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж компаниудын дэргэд хэвлэл мэдээллийн байгууллага байгуулагдаад ингээд өдөр хоногоор тэлээд аймгийн Засаг дарга, иргэдийн Хурал, аймгийн төвд байдаг сумын Засаг дарга, иргэдийн Хурал, зарим газар сургуулиуд ингээд төрийн өмчийн бүх нэгж байгууллагууд дэргэдээ хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг ингээд эрхлээд эхэлж байна. Тэнд сэтгүүлчдийг цалинжуулж байна, тэд нарт тоног төхөөрөмж авч өгч байна, контент үйлдвэрлэх ийм асуудал бол.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 6 номерт цаг нэмж өгье.

**С.Шаравдорж:** Тэгэхээр энэ асуудлыг хуулийн хэлэлцүүлгийн үед бид нэлээн их хөндөж ярьсан. Ялангуяа орон нутгийн сэтгүүлчдийн хэлэлцүүлгийн үеэр бүх 21 аймгийн сэтгүүлчид хэвлэлийнхэн байсан. Яг энэ асуудлыг л бүгд хөндөж ярьсан. Төр дэргэдээ хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албатай байхыг бол алба биш ажилтантай байхыг бол олон улсын жишиг байна. Тэр хүн бол нэг л хүн байхад хангалттай. Тэр хүн төрөө удирдлагаа хэвлэл мэдээллийн байгууллагуудтай л холбож өгөх л ийм үүрэгтэй. Нэг хүний асуудал ярьж байгаа болохоос биш бүхэл бүтэн 4, 5 хүний бүрэлдэхүүнтэй ийм албад байгуулаад ингээд байгаа нь энэ аягүй их газар авч байгаа. Сүүлийн жилүүдэд бүүр сумын сургууль одоо сум руу орчихсон явж байгаа энэ асуудал.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Дагасан хууль дээр Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль дээр 31.1.1-ийг дахин асууя. Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах гэсэн заалтыг хасаж байгаа юм байна. Тэгэхээр энэний цаана ямар агуулга агуулагдаж байгаа вэ гэдгийг бүгд мэдэж байгаа. Тэгэхээр хэвлэл мэдээллийн байгууллага, хэвлэл мэдээллийн сэтгүүлчид гэдэг юм уу байгууллагууд гүтгүүлээд явж, иргэд тэгээд гүтгүүлээд ингээд явах бололцоо боломж нь нээгдэж байна уу гэж харагдахаар байна. Энийг юу гэж ойлгож тайлбарлах вэ? Яагаад энэ заалтыг хасах хууль зүйн үндэслэл нь юу юм бэ? Энэ дээр нэг хариулт өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Н.Мягмар:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. ХЗДХЯ-ны ТНБД Мягмар. Энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бол хүний эрхийг хангах чиглэлийн багц хуулиудын хүрээнд боловсруулагдаж тусдаа үзэл баримтлалаар орж ирж хэлэлцүүлэгдэж байгаа хууль. Энэ хуулиудыг боловсруулах явцад хэлэлцүүлгийн үе шатад болон ажлын хэсгийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотойгоор энэ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд заасан, Зөрчлийн хуульд заасан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж зөрчих гэдэг энэ агуулгаар нэлээн өргөн зохицуулалт бүхий ийм хуулийн зохицуулалт болжээ. Энэ хүрээндээ иргэдийг үзэл бодлоо илэрхийлэх энэ эрхийг хэтрүүлэн хязгаарласан ийм хуулийн зохицуулалт болсон учраас энэ зохицуулалтыг хүчингүй болгох шаардлагатай байна гэдэг энэ асуудал яригдаад,

энэ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилсан юм. Тэгэхлээр үнэхээр юу гэдэг юм бусдыг юу гэдэг юм нэр төр.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофоныг сунгая.

**Н.Мягмар:** Бусдад хохирол учруулах энэ асуудал яриад, иргэний журмаараа хохирлоо нэхэмжлэх асуудал хэвээрээ байгаа. Гол нь иргэдэд энэ үүргийг хүлээлгээд, Зөрчлийн хуулиар торгууль шийтгэл оногдуулаад байгаа явдлыг иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх энэ эрхэд хэтрүүлэн халджээ гэдэг энэ агуулгаар энэ хуулийн төсөл дээр орж ирсэн юм. Мөн дагалдуулаад хэвлэл мэдээллийн байгууллагын энэ чиглэлийн хүлээсэн үүргийг энэ 2 дугаар зүйлээр нь хүчингүй болохоор ингэж оруулж ирсэн зохицуулалт байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхтүвшин гишүүн асуултаа асууна.

**Д.Энхтүвшин:** Хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой гол асуудал эдийн засгийн асуудал байдаг. Эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөгүй бол хэвлэл яг өөрөө бие даасан байдлаар дуу хоолойгоо илэрхийлэх боломжгүй байдаг. Тэгэхээр өнгөрсөн жилүүдэд харахад яг энэ төрийн энэ хуулийн 6.5 дээр төр болон төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа сурталчлахаар бол тусдаа тендер зарлахаар заачихсан байна л даа. Тэгэхээр энэ дээр би тоо асуух гэсэн юм одоогийн байгаа тоог. Нийт хэвлэл мэдээллийн зах зээл хэдэн ямар хэмжээтэй зах зээл байдаг юм бэ? Эндээс төр болон тусдаа төрийн байгууллага болон төрийн өмчит болон орон нутгийн өмчит компаниудын энэ хэвлэл мэдээлэлд зарцуулдаг үнийн дүн нь ямар үнэ дүнтэй байдаг юм бэ? Энэ талаар мэдээлэл өгөөч.

2 дугаарт нь энэ хууль дээр агуулгын хяналт цензуртэй холбоотой асуудлууд дурдагдсан байгаа. Тэгэхээр бид нарын ер нь судалгаагаар 70 гаруй хувь нь сошиалаас мэдээ авдаг. Тэгээд авч байгаа мэдээллийнхээ бараг 70 гаруй хувьд нь итгэдэггүй худлаа мэдээлэл байдаг гэсэн хариултууд өгсөн судалгаанууд байдаг. Тэгэхээр эндээс харахаар бид энэ алгоритмууд дээр жишээлбэл бусад ийм сошиал медианууд дээр үндэслэж мэдээллүүдээ авч байгаа. Энэний цаана нь ямар алгоритм ажиллаж байгаа гэдэг нь буцаагаад л яг энэ мөнгөтэй холбоотой, мөнгө төлсөн хүмүүс илүү жишээлбэл мэдээллүүд нь түгдэг, эсвэл өөр тодорхой энэ алгоритмууд яаж ажилладаг талаар та хэд мэдээлэл авах боломж ч юм уу, энэ чиглэлээр ажилласан үйл ажиллагаа байгаа юу гэсэн ийм 2 асуулт байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг хэн хариулах вэ? 5 номерын микрофон.

**Г.Гүнжидмаа:** Хэвлэл мэдээллийн зах зээл өөрөө яг бусад зах зээлтэй харьцуулбал маш ядмаг хэцүү. 400 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна гэдэг статистик байдаг хэдий ч энд яг үнэхээр эдийн засгийн хувьд бие дааж, хараат бусаар ажиллах нөхцөл боломж маш хязгаарлагдмал. Гол орлогын зах зээл бол зар сурталчлагч нараас 10 жилийн өмнө гол эх үүсвэр нь орж ирдэг байлаа. Өнөөдөр энэ нөхцөл байдал маань өөр болж, төрийн байгууллагуудаас гол санхүүжилт буюу дэмжих энэ нөгөө мэдээлэл сурталчилгааны зардал орж ирээд байгаа нь өөрөө нөгөө эдийн засгийн утгаараа хэвлэл мэдээлэл бие даасан хараат бус байдлаа ингээд улам бүр алдаж байгаа нэг ийм сул тал байна. Энэ зах зээлийг бүрэн дүр зургаар нь судалдаг статистик

болоод рейтингийн судалгаанууд төдий л амжилттай явж чадахгүй байна. Яг үнэхээр хэдэн төгрөгийн зах зээл эргэлдэж байгаа бол энэ бас харилцан янз бүрийн мэдээллүүд байдаг. Энэ өөрөө ил тод биш байгаад байна.

Тэгэхээр бид нарын хувьд хэвлэл мэдээллийн салбар өөрөө маш хүнд нөхцөл байдалд байгаа учраас энийг бид яг энэ нийгмийн нэг дэд системийнх нь хувьд босгож ирэх, энд өөрийнх нь үүрэг хариуцлагыг нь өнөөдөр олгож оногдуулах энэ нөхцөлөө хийхэд нь туслах ёстой байна. Тэгэхээр нэг талаас төр өөрөө гол дэмжигч санхүүгийн хувьд дэмжигч нь болчихсон, нөгөө талд гол өрсөлдөгч нь болчихсон ийм нөхцөл байдалд мэргэжлийн сэтгүүл зүй, редакцтай хэвлэл мэдээллийн байгууллагуудад цаашаа өндийхөд маш хүнд ийм цаг үе байгаа учраас бид энэ ялгаа заагийг энэ хууль дээр нэлээн оруулж ирэхээр хичээсэн байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сайнзориг гишүүн. Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Тэгэхээр энэ санхүүжилттэй холбоотой юман дээр нэлээн дорвитой арга хэмжээ авахгүй бол засаглалын хувьд жишээлбэл улс төрийн намууд, нам нэлээн үүрэг рольтой болчихсон. Улсын Их Хурал нь бие даасан үйл ажиллагаа явуулахад нэлээн төвөгтэй болчихсон, ЗГ бүхэлдээ жишээлбэл Улсын Их Хурлаа бараг хянах хэмжээний давхар дээлтэй олон сайд нартай болчихсон. Тэгэхээр энэ их эрх мэдэл төвлөрч байгаа үед уг нь энэ тэнцвэрийг бага хэмжээгээр ч гэсэн хязгаарлах зүйл нь яг энэ хэвлэл мэдээлэл байгаа. Гэхдээ яг энэ үүргээ эдийн засгийн асуудлаасаа болоод хангаж чадахгүй байгаа учраас тэгэхээр бид яах вэ яг бодит байдлаар цаад хөрс суурь нь хангагдахгүй учраас бэлгэдлийн шинжтэй болоод л явах шинжтэй байна. Тэгэхээр улс төрийн хувьд эсрэг үзэл бодолтой хүн рүүгээ дайрдаг тролл арми санхүүжүүлдэг энийг төсөв татвар төлөгчдийн мөнгөөр хийгээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ байдлаас яг энэ хууль гарч чадна гэдэгт эргэлзээтэй байгаад байна л даа. Тэгэхээр яг тэр цаад эдийн засгийн саяын тоог л олж авбал хэрвээ байдаг өгвөл зүгээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Алтангэрэл гишүүн, Алтангэрэл сайд хариулъя.

**О.Алтангэрэл:** Энхтүвшин гишүүний хөндөөд байгаа асуудал бид нарын байнга ярьж байгаа асуудал байгаад байгаа юм. Тэгээд яагаад бид энэ төрийн байгууллага болоод төрийн өмчит компаниуд ингээд сонгон шалгаруулалт буюу тендерийн үндсэн дээр энийгээ ингээд шалгаруул гээд байгаа гэхлээр яг үндсэндээ нийгмийн хариуцлагын хүрээнд гэдэг юм уу, олон юмны далбаан дор нэг үйл ажиллагаа явуулахдаа тэрийгээ сурталчилж байгаа нэрийн дор гаргаад байгаа мөнгөний задаргааг бид тооцох ер нь боломжгүй юм байна лээ. Төрийн өмчийн олон тэрбум, их наядаар тоологдох орлоготой компани нэлээн олон тэрбумыг ингээд нийгмийн хариуцлагын хүрээнд гэдэг юм уу үйл ажиллагаа явуулчихаад, тэрнийхээ багахан хэсгийг тэр дотроо тавиад хэвлэл мэдээлэл гээд тавьчихаад ингээд явж байгаа энэ тоог бид нийлүүлэх бололцоогүй юм байна лээ. Тэгэхээр бид ямар ч байсан хориглож өгье. Та нар ямар ч байсан нээлттэй сонгон шалгаруул, тендер зарла, энэ олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл дунд нь зарла, мэдээллээ өг, ингэж байж яв гэдэг зарчмыг л бид эхний ээлжид тусгаад байгаа юм. Дагаад ярих юм нь ерөөсөө бусад хуулиуд дээр ч гэсэн Хэмнэлтийн хууль дээр байдаг юм уу, олон хуулиуд дээр олон зохицуулалт хийж байж энэ асуудал цэгцрэх юм байна лээ. Бид үндсэн зарчмаа л нэг юм энд хийчихээд байгаа нь энэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Баярлалаа. ТББХ-н дээр орж ирээд асуулт асууя гэж бодож орж ирлээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийг төслийг хэлэлцээд явахыг зарчмын хувьд дэмжиж байна. Би энэ хуулийн төслийг өмнө нь боловсруулах ажлууд дээр оролцож гаргаж байсны хувьд болж байсан процесс алдаа дутагдлуудаа бол мэдэж байгаа. Тэгэхдээ эдгээр зүйлүүд засагдаж орж ирээгүй. Би уг нь яах вэ салбарын сайдтай уулзаад хэлж л байсан. Ер нь энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Хэвлэл мэдээллийн байгууллагын хууль 2-ыг тусад нь хийх ёстой юм байна. Энэ ингээд зарчмын асуудлууд чинь холилдохоороо бүх нөхцөл байдлууд буруу явчхаад байна гэдэг зүйлийг хэлж байсан. Тэгээд энийг ерөөсөө үргэлжлүүлж ажиллаагүй л байна л даа. Одоо яг энд сууж байгаа хүмүүстэй би хамтраад л энэ төсөл дээр сууж байсан. 3, 4 жил хэрэлдээд л явж байсан. Ойлголцол хүрэх, хүрэхгүй юмнууд ч байдаг ингээд яваа юм. Тэгэхээр уг нь энэ асуудлыг ингээд 2 салгаж орж ирээд, зарчмынх нь хувьд явчихсан бол илүү их амар байх байсан юм. Тэгэхээр би энэ дээр Хууль зүйн сайд ямар байр суурьтай байна вэ? Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль, Хэвлэл мэдээллийн байгууллагын тухай хууль гээд 2 салах ёстой байсан энэ дээр ямар байр суурь байна вэ?

2 дугаарт ерөөсөө энэ хэвлэл мэдээллийн салбар дээрх нэг зүйлийг бид мартаад байгаа. Энэ нь нэг талдаа хөрөнгө оруулж байгаа буюу эзэд буюу энэ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг эзэмшиж байгаа этгээдүүдээс гадна энд ажиллаж байгаа сэтгүүлчид гээд 2 хүн байгаад байгаа юм. Үүний цаана 3 дахь тулгуур багана болох мэдээлэл авах гэж байгаа олон нийтийн эрх ашгийг ерөөсөө бодолцож энэ хууль ерөөсөө тэр хэсгүүдийг нь бүгдийг нь хассан байна. Тэгээд ерөөсөө олон нийтэд ийм худал ташаа мэдээлэл явдаг, хэвлэл мэдээллийн байгууллагын өгч байгаа мэдээлэл дунд нэр хүнд, алдар хүнд нь хохирсон тохиолдолд гомдол гаргаад явна гэхээр буцаагаад яг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зөвлөл ч юм уу нэг ийм юманд өгнө гээд байгаа юм. Энэ Ёс зүйн зөвлөлийг бүрдүүлж байгаа этгээдүүд чинь хэвлэл мэдээллийн байгууллага сэтгүүлчдийнхээ талаас бүрдүүлж байгаа учраас шударгаар шийдэхэд бол хэцүү.

Тэгэхээр бусад улс оронд энэ асуудлыг шийдэхийн тулд хэвлэл мэдээллийн арбитр гэж байдаг. 3 бүрэлдэхүүнтэй арбитрыг сонгодог. Нэг талдаа гомдол гаргаж байгаа этгээд 1 арбитраа сонгочихно, нөгөө талдаа сэтгүүлч 1 арбитраа сонгочихно, ингээд 2 арбитр дундаасаа 1 арбитр ч юм уу. Ийм байдлаар ингээд зохистой байдлаар энэ хэвлэл мэдээллийн ёс зүйн асуудлыг шийддэг юм. Шийдэх нь зөв байгаад байгаа юм. Өнөөдрийнх шиг явж байгаа энэ сайн дурын гишүүнчлэлтэй энэ байгууллагуудаар ёс зүйн асуудлаа шийдүүлнэ гэхэд эргэлзээтэй. Тэгээд буцаад л энэ хэвлэл мэдээлэл буруу мэдээллүүд нь залруулагддаггүй, эргээд цагдаа, шүүхийн байгууллагаар явах урт удаан процесс үргэлжилнэ. Тийм учраас энэ асуудлыг үүсгэхгүй байх үүднээс энэ хэвлэл мэдээллийн арбитрын асуудал дээр ямар байр суурьтай байна вэ?

2 дугаарт эх сурвалжаа нууцлах асуудлыг дэмжиж байгаа. Тэгэхдээ ямар тохиолдолд нууцлах вэ, ямар тохиолдолд шүүхийн оролцоотой илчлэх вэ, нээлттэй болгох вэ гэдэг асуудал энэ ерөөсөө зүйлээр алга байна. Зөвхөн Эрүүгийн процессын хууль дээр биччихсэн байна. Уг нь энд дагалдаж боловсруулагдаж байсан хууль дээр.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ? Алтангэрэл сайд хариулъя.

**О.Алтангэрэл:** Урьд нь хэд хэдэн удаа өргөн бариад, хэлэлцүүлэгдэж байгаад буцаж байсан. Нийтдээ энэ чинь 4 удаа өргөн баригдсан хууль шүү дээ. Яригдаад л яригдаад байдаг ерөөсөө батлагддаггүй. Тэгээд энэ хуулийн төсөл яаман дээр их удаан явсан юм байна лээ. Тэгээд би Хууль зүй, дотоод хэргийн сайд болоод ажлын хэсгээ зарим нэг байдлаар шинэчлээд их олон уулзалтууд, олон хэлэлцүүлэг хийгээд явсан. Тэгэнгүүт ний нуугүй хэлэхэд энэ хуулийн төсөл унаад байдаг, болдоггүй, сэтгүүлчид хоорондоо ойлголцдоггүй энэ зүйл нь хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой яг тэр хэсэг дээрээ ирээд л маргалдаад эхэлдэг юм байна лээ. Гэтэл энэ байгууллага ярьж байх хооронд, байгууллага ярьж байх хооронд хамгаалагдах ёстой энэ үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хамгаалалттай холбоотой, сэтгүүлчдийн эрх зүйн байдалтай холбоотой, сэтгүүл зүйн бас эрх зүйн зохицуулалттай холбоотой олон асуудлууд орхигдоод олон арван жил яваад байна. Ийм учраас энэ удаагийн хууль дээрээ энэ ямар ч байсан өөрийн зохицуулалттай байгууллага байж болно гэдэг үндсийг нь оруулчихъя. Цаашдаа Байгууллагын тухай хууль бичигдээд ингээд явах бүрэн орон зайг үлдээгээд, ямар ч байсан сэтгүүл зүйн мэргэжлийн энэ үйл ажиллагаагаа яаж хамгаалах юм, энэ эрх, эрх чөлөөтэй холбоотой ямар зохицуулалт хийх юм гэдэг энэ асуудал руугаа анхаараад явсан. Таны анхааруулж хэлж байсан зүйлүүд бид нарыг энэ хуулийн төслөө боловсруулж хийхэд нэлээн түлхэц болсон гэдгийг хэлье.

Энэ мэдээлэл авах гэж байгаа олон нийтийн эрх ашиг гэж хэлж байгаа. Ер нь үнэн, мэдээлэл авах гэж байгаа олон нийтийн эрх ашигтай холбоотой зүйлүүдийг бид ярихаас аргагүй. Тэгэхдээ жишээлбэл бид энэ Хэвлэл мэдээллийн зөвлөл гэдэг юм уу, сэтгүүлчдийн өөрсдөө бий болгосон бүтцийг бид бэхжүүлж цааш нь улам яаж авчих вэ гэж энэ хандлагаас хандахгүй бол жишээ нь яах вэ сайн дурын гишүүнчлэлтэй гэдгээрээ л тэгж байгаа юм. Заавал гишүүнчлэлтэй байгаа нийтийн эрх зүйн хуулийн этгээд энэ хуулиар байгуулаад өгчихсөн Хуульчдын холбоо дээр, мөн Өмгөөлөгчдийн холбоон дээр хүний амь амьдралтай холбоотой өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зүйлийг хуульчид нь өөрөө суугаад шийдээд л явж байгаа. Мөн энэчээнээс дахиад цаашаагаа өөр бусад байгууллагуудад хандах эрх нь нээлттэй байдаг шиг бид хуулийн төсөл дээрээ зориуд энэ гомдол гаргаж байгаа үйл ажиллагаа нь хүн, хуулийн этгээдийн редакц болон шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй гэж өгсөн юм.

Ер нь энэ өөрийн зохицуулалтын байгууллага буюу Хэвлэл мэдээллийн зөвлөл энэ байгууллагуудын үйл ажиллагаа улам сайжраад, өөрсдөө өөрсдийн зохицуулалтын байгууллагынх нь өөрсдийнхөө салбарыг хянаж байгаа үйл ажиллагаа нь цаашдаа бүүр сайжраад ингээд явах байх. Энэчээнээс гарч байгаа дүгнэлт бол өнөөдөр практик дээр юу болж байна вэ гэхлээр эдгээр энэ Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс гаргасан дүгнэлт ч юм уу, иргэний процесс, эрүүгийн процесс дээр энэ бол тийм дүгнэлт гарчихсан байна энэ таны буруу, зөв байна гэхэд голлох зонхилох нотлох баримт болоод хэрэглэгдээд явдаг ийм байгаа.

Энэ эх сурвалжаа нууцлах эрх дээр бол бид яах вэ эрүүгийн процессын өөрчлөлтийг хийчихсэн. Хэлэлцүүлгийн явцад ярих зүйл нэлээн олон байгаа. Яагаад байгаа гэж хэлж байна вэ гэвэл Улсын Их Хурал дээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн ажлын хэсэг гараад, манай Лодойсамбуу гишүүн



ахлаад явсан, нэлээн олон зүйлүүд гарсан. Энэ дээр зарчмын шинжтэй нэмж оруулах одоогийн төсөл дээр зөрөөтэй энэ тэр зүйлүүд байгаа. Тэгээд юу гэж ярьсан бэ гэхлээр ямар ч байсан хэдүүлээ хэлэлцэж эхэлье. Сая таны хэлж байгаа шиг ч юм уу, бусад манай Лодойсамбуу гишүүний ажлын хэсгээс гаргаж байгаа саналуудыг хэдүүлээ ярилцаад, ингээд ажлын хэсэг байгуулаад, нэлээн том ажлын хэсэг байгуулаад явъя. Үнэхээр энэ ажлын хэсгийн хүрээнд ярьж байгаад зарчмын зөрүүтэй ойлголцохгүй юм уу, энэ хуулийн төсөлд оруулж болохгүй гэдэг юм уу ийм зөрүүтэй асуудал гарвал бид нэг ухраад энэ асуудлаа дахиж хэлэлцье гэсэн ийм хандлагатай байгаа гэдгээ танд хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сайнзориг асуулт тодруулъя.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Тэгээд Байнгын хорооны дарга тал талын төлөөлөлтэй ажлын хэсэг байгуулахад анхаарч өгөөч. Би ажлын хэсэгт орж ажиллах сонирхол байна. Лодойсамбуу гишүүний ажлын хэсэг дээр бид 2 байгаа. Тэгэхдээ боловсруулах гэхээсээ илүүтэй ЗГ-ын өргөн барьсан төслийг сайжруулаад явахыг хичээнэ.

Дээрээс нь яах вэ энэ дээр зөвхөн эх сурвалжаа нууцлах асуудал, гэрчээр дуудагдах асуудал чинь эрүүгийн асуудал биш байхгүй юу даа. Бид хэд юмыг ингээд дутуу орхиод байна. Захиргаан дээр ч дуудагдаж болно, иргэний кэйс дээр дуудагдаж болно бүх зүйл дээр. Ингээд таллаад ингээд мухарлаад нэг ийм тал дутуу юм орж ирэхээр ерөөсөө юм шийдэж болдоггүй. Тэгээд ер нь гол нь нөгөө мэдээллийг үнэн зөв мэдээлэл авах гэж байгаа иргэдийн эрх ашгийг авч үзэх, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага байсан ч гэсэн дэргэдээ арбитртай байх асуудлыг тавих ёстой. Энэ бол Хуульчдын холбооноос өөр шүү. Тэнд бол хуульчид байгаа. Энэ чинь яаж нотлох баримтыг цуглуулах, хэнтэй ямар процессоор явахаас эхлээд мэргэжлийн шинжээч, хуульч нь ажиллаад гэхдээ сэтгүүлч нараасаа бүрдсэн арбитр байдаг юм уу ийм зүйлүүд нь явж байж шийдэхгүй бол нэг талыг барина. Хэвлэл мэдээллийн зөвлөл одоо сэтгүүлч.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Түрүүн тэр Сандаг-Очир гишүүн хөндөж байсан хууль зүйн дүгнэлтийг ер нь хаана хэрэгжүүлэх юм бэ гэж. 1 дүгээр асуудал мэдээж нэгэнт Байнгын хороон дээр орж ирж танилцуулж байгаа бол хууль зүйн дүгнэлттэй холбоотойгоор гишүүд асуулт асууж, санал хэлэх ийм нээлтийг дэгэн дээр нээж өгмөөр юм байна. 2 дугаарт ажлын хэсэг дээр бол хууль зүйн дүгнэлтийг нэлээн сайн ашиглаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр мэдээж энэ хуультай холбоотойгоор ажлын хэсэг байгуулагдана. Тэгээд энэ хууль зүйн дүгнэлттэй холбоотой асуудлууд, гишүүдтэй холбоотой асуудлууд яригдаад, засаж залах зүйлүүд хийгдээд явах байх гэж бодож байна. Номинчимэг гишүүн асуулт асууна.

**О.Номинчимэг:** Би 3 ерөөсөө тодорхой асуулт асууя. Ерөнхийдөө энэ хуулийг шинэчлээд орж ирээд, тодорхой зохицуулалтуудыг орж ирэх, удаан хүлээгдсэн хууль орж ирж байгаад талархаж байна. Тэгэхдээ сайн маш сайн хэлэлцүүлэг хийж, цаашид бид ажиллах ёстой гэж бодож байгаа. 3 асуулт байна. 1 дүгээрт нөгөө хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч гэж хэнийг юуг хэлэх вэ гэдэг нь ойлгомжтой тийм ээ хуульд. Үүн дээр нэмээд чөлөөт сэтгүүлч гэсэн нэг тийм ойлголтыг хуульд шинээр тусгаж орж ирж байгаа юм байна. Тэгээд тэд нарын эрхэлж байгаа ажлыг зохицуулахаар хуульд тусгасан юм байна. Тэгээд чөлөөт сэтгүүлчийг ийм идэвхтэй нийтлэл бичдэг сайн дураараа эсвэл өөрийнхөө хүсэл

зорилгоороо бичдэг, контент үйлдвэрлэдэг энэ иргэдээс ер нь яаж ялгах вэ? Жишээлбэл нөгөө Амараа либерти гээд нэг залуу байдаг юм шүү дээ нэлээн их нөгөө контент бүтээдэг, ярьдаг. Энэ Амараа либерти маань тэгэхээр чөлөөт сэтгүүлчид орох юм уу эсвэл influencer content бүтээгч гэдэгт орох уу? Энэний зааг ялгааг та бүхэн ер нь яаж гаргана гэж бодсон бэ?

2 дугаарт хэвлэл мэдээллийн олон янз байдал гэсэн дотор олон нийтийн, арилжааны, хамтын гэсэн 3 төрлийг багтааж орж ирсэн юм байна. Тэгээд хамтын гэдэг төрөл ангиллыг илүү жоохон тодруулж өгөөч, хувьцаат компани байж болох юм уу? Жишээ нь Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз гээд байдаг олон шүүмжлэл дагуулдаг. Гэхдээ энийг илүү хувьцаат хэлбэр лүү шилжүүлэх боломжтой гэж харж байгаа юу?

3 дахь асуулт маш их шүүмжлэл дагуулдаг юм бол төр дэргэдээ өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлгүй байна гэдэг заалт өмнөх хууль дээр ч байсан, одоо ч уг нь хэрэгжиж байгаа. Гэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага гэсэн баримт бичиг байхгүй боловч ерөнхийдөө төрийн байгууллагуудын хэвлэлийн алба байдаг юм уу, бусад албан бус бүтцээр зарим редакцын үнэндээ хийж чадахгүй байгаа контентыг ч гэсэн төр нь хийдэг, түгээдэг, олон нийтэд хүргэдэг энийг бол бид бүгдээрээ л харж үзэж байгаа. Тэгээд ямар сайндаа нөгөө судалгаа хийгээд үзэхээр Олон нийтийн телевизээр гарч байгаа контентуудын бараг талаас их хувь нь төр болон улс төрчийн ч байдаг юм уу, төрийн байгууллагаас хийсэн контент байна. Чөлөөт нөгөө уран бүтээлч, нөгөө дөрөвдөгч засаглалын 4 дэх хяналтыг хэрэгжүүлдэг сэтгүүл зүйн салбар хэвлэл мэдээллийн салбарын контент гэхээсээ илүү ийм юм болоод байна гэдэг шүүмжлэлийг дагуулдаг. Тэгэхээр энийг яах юм бэ? Энэ дээр ямар нэгэн зохицуулалт энэ хуулийн төсөлд ер нь орж ирсэн байгаа юу?

**Ж.Бат-Эрдэнэ:** Алтангэрэл сайд хариулъя.

**О.Алтангэрэл:** Тэр хэвлэл мэдээллийн олон талт байдлын талаар манай ажлын хэсэг хариулахад бэлдэж байгаарай. Энэ чөлөөт сэтгүүлч гэдэгт бид бол ингэж байгаа юм. Сэтгүүл зүйн үйл ажиллагаа хэвлэл мэдээллийн байгууллагын редакцад хамааран орон тооны болон орон тооны бус байдлаар эсвэл бие даан чөлөөт байдлаар гүйцэтгэж байгаа хүнийг гээд. Ер нь маш товчхондоо freelancer. Тэгэхдээ тэр хүний үйлдвэрлэж байгаа контент, тэр хүний бичиж байгаа эсвэл үйлдвэрлэж байгаа контент, бичиж байгаа нийтлэл гэдэг юм уу энэ сэтгүүл зүйн бүтээлүүд нь энэ хуульд заасан хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжиж, олон нийтэд хүрч байгаа хүнийг бид хамруулъя гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл жишээ нь нэг жишээ татъя. Монгол Улсын Эрүүгийн хуульд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулах гэдэг гэмт хэрэг байгаа юм. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулах гээд. Үүгээр шийтгэгдээд ял шийтгэл аваад яваа хүн байхгүй. Гэтэл үндсэндээ энэ зүйл анги Эрүүгийн хуульд орсон, ороод хэрэгжээд явж байгаа энэ 20 гаруй жилд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хэнд ч саад болоогүй юм уу гэдэг асуулт гарч ирж байгаа юм. Тэгээд нөгөө талдаа юу гарч байна вэ гэхээр тэгвэл сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа гэдэг чинь юу юм бэ, сэтгүүлч чинь хэн юм бэ гэдэг асуудал гарч ирж байгаа учраас бид энэ хууль дээр ингээд л тодорхойлоод байгаа юм. Тэгэхлээр яаж байна вэ гэхээр энэ хуулиар тодорхой хэмжээний шаардлага тавьж байгаа. Өөрийн зохицуулалтын байгууллагатай байж болно. Энэ, энэ

нийтлэлийнхээ хариуцлагыг өөрсдөө хүлээ. Түрүүний манай Сандаг-Очир гишүүний асууж байсан тэр олон нийттэй холбоотой, эрх ашигтай холбоотой зүйлүүд дээр хариуцлага хүлээлгэж байгаа учраас нөгөө талдаа хэвлэн нийтлэх эрх чөлөөг нь нээж, хамгаалж өгье. Харин энэ нь өнөөдөр нийгмийн сүлжээнд байгаа бидний influencer гэж нэрлэдэг олон дагагчтай гэдэг, олон хүнд хүрдэг тэдгээр хүмүүсийн үйл ажиллагаанаас өөр. Сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа гэдэг бол өөр юм гээд ямар шинжээр өөр гэдгийг нь тодорхойлоход тэгээд таны асуусан асуулт бол яг энэ хуулийн хүрээнд, энэ хуулийн төслийн хүрээнд тодорхойлогдож байгаа. Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжиж өөрийнх нь бүтээл олон нийтэд хүрч байгаа хүний чөлөөт уран бүтээлч гэж байгаа юм. Үндсэндээ нэг хүн нийтлэл бичдэг байна, нэг редакцад хамааралгүй, өөрөө бичсэн нийтлэлийнхээ хүрээнд, бэлдсэн контентынхоо хүрээнд газруудаас төлбөр аваад яваад байдаг байж болно. Өөрөө чөлөөтэй сэтгүүлч. Тэгэхээр энэ хүний үйл ажиллагааг бид хамгаалах л ёстой. Яагаад гэвэл энэ хүний хийсэн контент, хийсэн бүтээл нь хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн бүтээгдэхүүн болж олон нийтэд хүрч байгаа учраас гэсэн ийм логикоор юм.

Энэ төр дэргэдээ хэвлэл мэдээлэлтэй байх асуудал түрүүнээс хойш нэлээд олон удаа яригдлаа. Тэгэхээр яах вэ маш товчхондоо хэлэхэд бид төрийн төрөөс шууд болон шууд бусаар хэвлэл мэдээллийн зах зээлд болон хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд нөлөөлдөг нөлөөллийг энэ хуулийн хүрээнд байж болох хэмжээгээр нь хязгаарлахыг зорьсон. Хамгийн гол үзүүлж байгаа нөлөөлөл бол төрийн байгууллагын зүгээс хажуудаа албан бус нэртэй боловч хэвлэл мэдээллийн хэрэгслийг бүтэц байгуулдаг, хүмүүс цалинжуулдаг, техник хэрэгсэл байдаг. Энэ хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай холбоотой контент бүтээлгэх, нэвтрүүлэг хийлгэх, сурталчилгаа хийлгэх ч гэдэг юм уу ийм байдлаар төрийн байгууллага болон төрийн аж өмчит аж ахуйн нэгжүүд энэ зах зээл рүү хэт хутгалддаг. Тэгээд энэ үйл ажиллагааг нь та Үндэсний олон нийтийн радио, телевизийн жишээг хэлж байна. Энэ шиг ийм зохисгүй нөлөөлөл их байгаа учраас бид сонгон шалгаруулалтын үндсэн дээр буюу тендерийн үндсэн дээр тэр үйл ажиллагаагаа явуулах, тэгээд цаашдаа дагаад бид ер нь хууль, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох шаардлагатай байна. Өөр бусад хуулиудаар ч гэсэн энэ чиглэлийг зохицуулах шаардлагатай байна гэж үзэж нэлээн олон зохицуулалтыг тусгаад байгаа юм. Түрүүний асуулт дээр 2 дахь асуулт дээр 1 номерын микрофон.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн 5 номер уу? 5 номерын микрофон, битгий дар.

**Г.Гүнжидмаа:** Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ хуулийн нэг үзэл санаа нь олон талт, олон ургалч байдлыг дэмжих байгаа. Тэгэхээр нийтлэг утгаараа public, community, commercial гэсэн буюу олон нийтийн, арилжааны, хамтын гэсэн ийм 3 төрлийн хэвлэл мэдээлэл оршин тогтнож хөгжиж байна. Тэгэхээр бид тэр хамтын хэвлэл мэдээлэл гэдэг бол тодорхой сонирхлоороо нэгдсэн хүмүүс. Магадгүй нэг нийгмийн цөөнх бүлэгт, магадгүй сургуулийн хүүхдүүдэд яг тэд нарын эрх ашигт нийцсэн тийм бүлэгт зориулсан хэвлэл мэдээллийг хамтын хэвлэл мэдээлэлдээ оруулаад явж байгаа. Тэгээд энэ хуульд мөн дийлэнх Олон нийтийн радио, телевиз бол тусдаа хуультай, бусад бүх хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг арилжааны буюу ХХК-ийн зарчмаар ажиллах тэр нөхцөлийг нь тусгаж өгсөн нь ач холбогдолтой гэж харж байна. Сошиал медиа болоод мэргэжлийн хэвлэл мэдээлэлтэй холбоотой би нэг зүйлийг нэмэхэд.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 5 номерын микрофон.

**Г.Гүнжидмаа:** Амараа talk шоуг өөрөө бие дааж хийгээд youtube-р цацах нь энэ Үндсэн хуулийн 16.16-гийн хэрэгжилт юм. Хэн ч ингэж болно. Хуулийн хариуцлага нь бол Эрүүгийн хууль, Иргэний хуулиараа хэрвээ гүтгэвэл. Амараа talk show NTV телевизээр цацагдах юм бол энэний хариуцлагыг NTV телевиз хүлээх юм. NTV телевиз энэ хариуцлагаа ёс зүйн өөрийн зохицуулалтынхаа хүрээнд, хэтэрсэн байвал хуулийн хүрээнд ингэж хариуцлагаа хүлээнэ гэдэг энэ ялгаа заагийг оруулж ирсэн байгаа. Өмнө нь хэд хэдэн өөрийн зохицуулалттай холбоотой зүйлүүд яригдсан учраас түүн дээр нэг товчхон мэдээллийг хэлье. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт бол өөрсдөө хариуцлагаа хүлээнэ гэсэн зарчим, хэвлэл мэдээллийн, Сайнзориг гишүүний нөгөө гараад явчихлаа. Би тайлбар хэлэх гэж байгаад хоцорчихлоо. Монгол Улс 10 жилийн өмнө салбараараа эвлэлдэн нэгдэж, энэ хамтын нийгмийн чиг баримжаат үзэл санааг буюу нийгмийн социал демократ.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу? Хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Би энэ төрийн болон төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээр хэвлэл мэдээллийн алба байхыг хориглож байгаа, тэр тайлбараас бол асуудал хариуцсан ажилтантай байж болох ийм л хуульчлагдаж байгаа юм байна. Тэгээд төрийн байгууллагууд цаашдаа хэвлэл мэдээллийн үйл ажиллагаагаа сурталчлахдаа тендер зарлах юм байна. Тэгээд тендер зарлана гэдэг бол тэгээд бөөн будилаан шүү дээ. Бөөн авлига, хээл хахууль шүү дээ. Өнөөдөр ямар байгаа билээ гэхээр цүнхний компаниуд яадаг билээ. Яг тэрэнтэй адилхан олон дагагчтай гэдэг юм уу, том хэвлэл мэдээллийн албууд нь л хэдэн тендерт нь ороод л ингээд явдаг болох нь. Үндсэндээ жижиг гэдэг юм уу, цөөхөн дагагчтай гэдэг юм уу ийм контент, ийм мэдээллийн редакцууд үндсэндээ энэ тендерт чинь, тэгээд тендерт чинь хуулийн этгээд орох байх. Тэгээд энэ нь яаж хуульчлагдах юм бэ? Үндсэндээ жижиг гэж хэлж болох редакцууд, үндсэндээ энэ хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа энэ тендер сонгон шалгаруулалтад оролцож чадахгүйгээр эд нарыг шахсан ийм бодлого болчих вий дээ. Тэгээд нэг хэдэн цөөн тооны ингээд монопол хэвлэл мэдээллийн байгууллагууд гараад ирчхэв үү дээ. Юм болгоны тендерт оролцож, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах нэрийн доор. Манайхан чинь нэг юм ярихаар нөгөөдхийг гуйвуулах мушгих, сөргөөр ашиглахдаа гаргууд сайн шүү дээ. Тийм учраас энэ сонгон шалгаруулалт тендерийн цаана ямар булхай луйврууд байдгийг бүгд мэдэж байгаа. Тийм учраас хэвлэл мэдээллийн байгууллагууд маань цаашдаа ийм байдал руу ороод ингээд явчих эрсдэл үүсэх вий дээ гэдгийг нэгд би энийг хэлэлцүүлгийн шатдаа анхаарч үзнэ биз.

2-т тэр хүний нэр төр, алдар хүнд энэ эрх ашгийг тэр заалтыг хасаж байгаа нь нөгөө талаасаа сая хариултыг сонсоход хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хааж, хязгаарлаж зөрчил хуулиар арга хэмжээ авч байна гээд, цаана нь бас хүний нэр төрөө, алдар хүндээ гутаалгаж байгаа иргэдийн зүгээсээ харвал энэ асуудлыг юу гэж үзэх юм бэ? Энэ заалтыг хассанаараа. Өнөөдөр тэгээд нөгөө сайд ялаа хоёрыг сониноор цохиж алдаг гэдэг шиг ингээд л хэн нэгнийгээ таалагдаагүй, гэрээ

байгуулагдаагүй гэдэг юм уу, улс төрчдийг сөрөг хүчнийхнийгээ гээд л намнаж байгаа шүү дээ яг үнэнийг хэлэхэд хэвлэл мэдээллээр. Нотолгоотой, нотолгоогүй мэдээллээр. Ингээд л алдар, нэр хүндийг нь гутааж байгаа зүйлүүд олон байгаа шүү дээ. Энийг цаашдаа хэлэлцүүлгийн шатдаа анхаарах ёстой юм байна гэж би хувьдаа бодож байгаа юм. Энэ.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Лодойсамбуу гишүүн үг хэлье.

**Ч.Лодойсамбуу:** Баярлалаа. Сандаг-Очир гишүүн, Сайнзориг гишүүн, Энхтүвшин гишүүн бүгдийнх нь зөв л дөө. Тэгээд энэ хууль 4 дэхээ орж ирж байгаа. Хэдэн удаа орж ирэх, хэдэн хүн, хэдэн жил, хэдэн цаг ажиллах, хэдэн хуудас материал бэлдсэн байх эсэх нь 1 дүгээр асуудал биш, хамгийн гол нь зорилго биелсэн байх учиртай. Тэр утгаараа энэ хуулийн шинэчилсэн найруулгыг дэмжихгүй байгаагаа удаа дараа илэрхийлж байгаа. Гэхдээ Алтангэрэл сайд түрүүн хэллээ. Алтангэрэл сайдтай ярьж байгаад шинэчилсэн найруулга учраас тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг харилцан том ажлын хэсэг гаргаж байгаад явуулъя гэж. Ямар өөрчлөлтүүдийг ер нь хийх бодолтой байгаа вэ гэдгээ ер нь хэлчихье гэж бодож байгаа юм. Энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гээд хэвлэл мэдээллийн байгууллага талаасаа тэдгээрийн хүрээ хязгаарыг тогтоох, оролцоог нь хязгаарлах чиглэл рүүгээ биш үндсэндээ хэвлэн нийтлэх эрх чөлөөг хангах талаар л бид энэ хуулийнхаа анхны зорилгыг тийш нь чиглүүлэх хэрэгтэй гэж үзэж байгаа юм.

Жишээ татахад эх сурвалжаа нууцлах тухай их тодоор яригдаж байгаа юм. Ямар үед, яагаад эх сурвалж ер нь нууцлах, тэр нууцлаад байгаа эх сурвалжийг нь мэдэх шаардлага үүсээд байна гэхээр мэдээлэл олддоггүй манайд. Бүх мэдээлэл нууц далд. Тэгээд хэн нэг даргын гар дээр байдаг, хэн нэг даргаас хэн нэг нь олж аваад мэдээлдэг. Ингээд нэг бол хууль зөрчдөг, нэг бол эх сурвалжаа хийлгээд ингээд сэтгүүл зүйн дарамтад учирдаг 1-д.

2 дугаарт энэ төрийг энэ хэвлэл мэдээллийн зах зээлээс салгах энэ өөрчлөлтийг л зоригтой хийх хэрэгтэй. Энийг манай хэвлэл мэдээллийн байгууллагынхан, сэтгүүлчид маань ч гэсэн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэгж байж бид эрх чөлөөтэй үнэхээр ажилламаар байгаа юм уу, үгүй юм уу гэдэг сонголтоо бид хийх хэрэгтэй.

Илт худал мэдээлэл тараахтай холбоотой, гүтгэхтэй холбоотой энийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас удаа дараа зөвлөмж хүргүүлээд, манай Их Хурлын тогтоол гарсан 2024 онд. Энийг Эрүүгийн хуулиас ер нь гаргая гэдэг. Тэгээд энийгээ биелүүлэх л хэрэгтэй. Ёс зүй, тэр хүний нэр төртэй холбоотой энэ бол хуулийн үндсэн зарчим байдаг гэж би ойлгодог. Хууль бол хүнийг шийтгэхийн төлөө биш хүнийг хамгаалахын төлөө байдаг. Одоо бид хэн нэгэнд хариуцлага тооцох талаасаа биш, хэн нэг нь хохирохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хохирсон бол хохирлыг нь нөхөн төлүүлэх, эргээд энэ иргэнээ эрхийг нь хамгаалах тал руугаа л бид илүү анхаарах хэрэгтэй. Тэгэхгүй бол одоо бид хэн нэгнийг шийтгэх гээд л байдаг, мууг нь үзэх гээд л байдаг хуулиар. Гэтэл нөгөө талдаа яг хохирлыг нь барагдуулах энэ асуудал явах юм бол илүү бодитой үр дүн гарна гэдэг байдлаар энэ хуулийн ажлын хэсгийг ахлаад явах сонирхолтой байгаа. Надад байгаа ажлын хэсэг бол хэвлэлийн эрх чөлөөг хангах талаар дүгнэлт гаргах ажлын хэсэг байгаа. Тэгээд энэ ажлын хэсэг дээрээ нийлүүлээд ингээд явах ийм бодолтой байна даргаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 35.11-д энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэсэн байгаа. Үүнтэй уялдуулан санал хураалтыг явуулъя.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Миний, би дэмжсэн боловч аппарат ажилласангүй. Дахин энэ санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналыг гаргаж байна. Саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Бас яав энэ? Сандаг-Очир гишүүн, Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Санал хураалтаас хоцорчихлоо, дэмжиж байгаа. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хурааж өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Үгүй ээ уг нь дарж л байсан юм тэгээд энэ болохгүй яваад байна л даа. Дахиж явуулъя, энэ яг Сандаг-Очир гишүүнтэй адилхан шалтгаанаас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хүчингүй болгоё гэж байна тийм үү? Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна. Батын Батбаатар гишүүний санал гаргасны дагуу саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 18 гишүүнээс 10 гишүүн оролцож, 55,6 хувиар санал дэмжигдлээ. Санал хүчингүй болсон тул дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Санал хураалтад оролцож чадсангүй. Горимын санал гаргая. Санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Номинчимэг гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн төслийн дагуу санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдсэн тул санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулъя. Санал хураалт байгаа шүү дагах хуулиудаас. 18 гишүүнээс 10 гишүүн оролцож, 55,6 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ чинь бас яачхав? Одбаяр гишүүн.

**Э.Одбаяр:** Сая санал хураалт дээр төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Одбаяр гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн оролцож, 66,7 хувиар санал дэмжигдсэн тул санал хураалт хүчингүйд тооцогдлоо. Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 18 гишүүнээс 12 гишүүн оролцож, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар санал дэмжигдлээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх тухай хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах уу? Баярбаатар гишүүн танилцуулъя.

12.10 цаг

### **Хоёр. “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Дараагийн асуудалдаа орёе. Санал хураалттай шүү. Байнгын хорооны тогтоолын төсөл. Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Байнгын хорооны тогтоол. Нэр дэвшигчийг бүртгэх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.7 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

1. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд хүлээн авч, нэр дэвшигчээр бүртгэхээр тогтоосугай.

2. Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн хүсэлт материалыг хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороо Ж.Бат-Эрдэнэд даалгасугай. ТББХ-ны дарга Ж.Бат-Эрдэнэ гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбоотой үг хэлэх гишүүд байна уу? Алга. Тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд 18-аас 13 гишүүн оролцож, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

12.12 цаг

Өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хүрэлцэн ирсэн гишүүдэд талархал илэрхийлье. 20 40-ийн ажлын хэсгийнхэн Үндсэн хуулийн танхим руу шууд орно шүү.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА